

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Үйлдвэрлэл урлалын политехникийн коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/246-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:2616663 Цахим хаяг: naranchimegts@gaudit.gov.mn Аудитын менежер: С.Нацагдорж Утас: 260512 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn Аудитор: Б.Батхишиг Утас: 261729 Цахим хаяг: Batkhisigb@audit.gov.mn Пийк ОМ Аудит ХХК-ийн захирал: Б.Жаргалсайхан Утас:99862066 Цахим хаяг: peakomauditllc@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	19
4.1 Ерөнхий зүйл	19
4.2 Материаллаг байдал.....	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	20
4.5.1 Завсрын аудитын талаар.....	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
5.2 Албан шаардлага.....	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ҮЙЛДВЭРЛЭЛ УРЛАЛЫН
ПОЛИТЕХНИКИЙН КОЛЛЕЖИЙН
ЗАХИРАЛ Д.БУЯНДЭЛГЭР ТАНАА

2026.02.25 № 06/428
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 256,202.7 мянган төгрөгийн зөрчил илэрч бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нарийвчлан тооцож, боловсруулаагүйгээс тендерт оролцогч орж ирээгүй, цахим дэлгүүрт шаардлагатай материал байхгүй гэх шалтгаанаар 234,950.8 мянган төгрөгийн хичээл үйлдвэрлэлийн дадлагын материалыг шууд гэрээ байгуулан худалдан авсан;
- Бараа материалын дансанд бүртгэсэн 18,952.4 мянган төгрөг нь хөрөнгийн шаардлага хангаагүй зэрэг нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 41 дүгээр зүйлийн 41.1.1, 44.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дах заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд PEARSON BTEC олон улсын мэдээлэл технологийн хөтөлбөрийн үнэлгээний стандарт баталгаажуулалтыг амжилттай хийлгэж, олон улсын чанарын нэгдсэн менежментийн ISO9001:2015, ISO21001:2018 гэрчилгээг үргэлжлүүлэн хадгалсан байна.

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль 2023 онд шинэчлэгдэн батлагдсанаар мэргэжлийн боловсролын байгууллагууд гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчимд шилжиж, 2024 оны үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтээр 579,747.7 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 10 дугаар тогтоолын дагуу тус коллежийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой, 185 нэр төрлийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, дансны үнийг 282,100.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоож, бүртгэсэн байна.

Бусад асуудал

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 11 зорилтын хүрээнд 42 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлын хэсгийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,066,346,466.43	1,028,842,270.16
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	427,501,247.81	374,526,149.26
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	427,501,247.81	374,526,149.26
31210	Төгрөг	427,501,247.81	374,526,149.26
31211	Төрийн сангийн харилцах	427,501,247.81	374,526,149.26
33	АВЛАГА	114,930,000.00	105,006,800.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	16,056,800.00
33500	Бусад авлага	114,930,000.00	88,950,000.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	114,930,000.00	88,950,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	523,915,218.62	549,309,320.90
35100	Түүхий эд материал	399,081,373.77	395,662,476.27
35110	Тусгай зориулалттай материал	396,683,295.77	395,118,476.27
35130	Эм боох материал	2,398,078.00	544,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	13,272,503.00	14,770,280.78
35400	Хангамжийн материал	111,561,341.85	138,876,563.85
35410	Бичиг хэргийн материал	4,716,360.00	1,499,200.00
35420	Аж ахуйн материал	75,487,043.45	106,590,125.45
35430	Сэлбэг хэрэгсэл	4,092,338.40	6,092,338.40
35450	Барилгын засварын материал	2,570,700.00	-
35470	Бусад хангамжийн материал	24,694,900.00	24,694,900.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,109,034,395.24	7,490,862,993.30
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,109,034,395.24	7,490,862,993.30
39200	Биет хөрөнгө	6,842,596,820.24	7,224,917,943.30
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,478,767,910.33	6,663,024,868.33
39202	Хуримтлагдсан элэгдэл	(589,849,782.80)	(709,955,949.68)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	111,610,000.00	14,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(111,610,000.00)	(3,422,222.21)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	3,387,887,325.36	1,157,284,672.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,917,269,771.73)	(335,697,859.14)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	537,339,285.13	358,327,279.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(404,795,411.35)	(218,649,241.48)
39214	Бусад үндсэн хөрөнгө	310,435,804.57	316,897,466.46
39215	Хуримтлагдсан элэгдэл	(168,789,255.87)	(236,286,499.18)
39217	Ном	208,870,716.60	219,395,428.70
39300	Биет бус хөрөнгө	266,437,575.00	265,945,050.00
39301	Програм хангамж	2,462,625.00	2,462,625.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(985,050.00)	(1,477,575.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	264,960,000.00	264,960,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	8,175,380,861.67	8,519,705,263.46
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	99,109,171.00	74,600,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	99,109,171.00	74,600,000.00
41300	Өглөг	11,309,171.00	-
41360	Бусад өглөг	11,309,171.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	11,309,171.00	-
41400	Урьдчилж орсон орлого	87,800,000.00	74,600,000.00
41440	Бусад урьдчилж орсон орлого	87,800,000.00	74,600,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,076,271,690.67	8,445,105,263.46
51	Засгийн газрын хувь оролцоо	8,076,271,690.67	8,445,105,263.46

Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51100	Засгийн газрын оруулсан капитал	2,939,702,673.59	2,939,702,673.59
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	2,939,702,673.59	2,939,702,673.59
51200	Хуримтлагдсан үр дүн	(318,664,508.09)	50,169,064.70
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,786,394,351.08)	(318,664,508.09)
51220	Тайлант үеийн үр дүн	1,467,729,842.99	368,833,572.79
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,455,233,525.17	5,455,233,525.17
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	8,175,380,861.67	8,519,705,263.46

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	7,825,635,700.85	7,817,386,776.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,434,053,700.85	7,817,386,776.40
120	Нийтлэг татварын бус орлого	1,434,053,700.85	814,054,975.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	745,641,570.00	582,499,470.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	745,641,570.00	582,499,470.00
120009	Бусад орлого	-	44,640,100.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	687,376,490.37	180,858,032.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	1,035,640.48	6,057,373.40
122	Тусламжийн орлого	-	7,003,331,801.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	7,003,331,801.00
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	7,003,331,801.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	7,003,331,801.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,391,582,000.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	6,391,582,000.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,391,582,000.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	6,357,905,857.86	7,448,553,203.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,357,905,857.86	7,448,553,203.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,121,702,019.86	7,118,375,663.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,965,041,809.07	4,756,697,144.51
210101	Үндсэн цалин	2,212,577,755.04	2,370,801,515.99
210102	Нэмэгдэл	1,187,351,061.75	1,800,664,198.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	210,382,354.28	279,696,500.00
210104	Урамшуулал	354,730,638.00	305,534,930.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	501,762,311.01	579,770,109.69
210201	Тэтгэврийн даатгалын зардал	344,522,539.71	405,137,978.45
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	40,250,883.84	44,720,617.78
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	21,052,875.79	23,601,009.90
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	19,047,073.70	21,088,566.55
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	76,888,937.97	85,221,937.01
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	161,625,825.79	168,019,793.25
210301	Гэрэл, цахилгаан	53,073,484.30	75,970,304.44
210302	Түлш, халаалт	100,374,824.65	82,895,937.65
210303	Цэвэр, бохир ус	8,177,516.84	9,153,551.16
2104	Хангамж, бараа материалын зардал	14,061,800.00	175,097,661.62
210401	Бичиг хэрэг	14,061,800.00	13,854,770.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	161,242,891.62

Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2105	Нормативт зардал	128,355,420.00	193,660,650.75
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	534,220.00	4,763,150.75
210502	Хоол, хүнс	127,821,200.00	188,897,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	57,307,260.00	76,236,050.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	12,270,260.00	39,005,550.00
210604	Урсгал засвар	45,037,000.00	37,230,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	156,193,296.00	159,717,216.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	156,193,296.00	159,717,216.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,137,354,297.99	1,009,177,037.79
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	315,040,396.07	207,863,342.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	568,801,956.00	394,155,693.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	253,511,945.92	407,158,002.79
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	236,203,838.00	330,177,540.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	236,203,838.00	314,120,740.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,773,838.00	45,433,240.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	169,560,000.00	211,094,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	36,870,000.00	57,593,500.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	16,056,800.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	16,056,800.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,467,729,842.99	368,833,572.79
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	1,467,729,842.99	368,833,572.79

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	7,092,313,713.75	7,627,194,571.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	700,731,713.75	7,627,194,571.00
120	Нийтлэг татварын бус орлого	700,731,713.75	623,862,770.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	700,731,713.75	579,222,670.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	700,731,713.75	579,222,670.00
120009	Бусад орлого	-	44,640,100.00
122	Тусламжийн орлого	-	7,003,331,801.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	7,003,331,801.00
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	7,003,331,801.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	7,003,331,801.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,391,582,000.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	6,391,582,000.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,391,582,000.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,217,282,324.94	7,271,114,358.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,217,282,324.94	7,271,114,358.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,982,848,486.94	6,741,127,060.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,961,604,061.34	4,756,697,144.51
210101	Үндсэн цалин	2,199,777,916.26	2,602,736,716.49
210102	Нэмэгдэл	1,195,551,296.67	1,571,643,575.13
210103	Унаа хоолны хөнгөлөлт	210,998,920.31	278,496,437.56
210104	Урамшуулал	355,275,928.10	303,820,415.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	492,245,408.74	579,770,109.69
210201	Тэтгэврийн даатгалын зардал	336,534,110.74	405,137,978.45
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	38,890,570.18	44,720,617.78
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	21,040,679.82	23,601,009.90
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	19,034,877.73	21,088,566.55
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	76,745,170.27	85,221,937.01
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	163,582,401.08	168,019,793.25
210301	Гэрэл, цахилгаан	61,456,499.67	75,970,304.44
210302	Түлш, халаалт	91,431,461.77	82,895,937.65
210303	Цэвэр, бохир ус	10,694,439.64	9,153,551.16
2105	Нормативт зардал	128,277,000.00	189,184,800.00
210502	Хоол, хүнс	128,277,000.00	189,184,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	258,166,805.00	151,995,201.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,761,100.00	15,005,971.00
210602	Тавилга	-	1,069,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	47,123,760.00	41,047,150.00
210604	Урсгал засвар	196,281,945.00	94,872,880.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	155,799,296.00	179,514,716.00

Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	155,799,296.00	179,514,716.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	823,173,514.78	715,945,296.25
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	345,084,745.78	358,684,027.75
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	478,088,769.00	345,261,268.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	234,433,838.00	330,914,040.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	234,433,838.00	314,857,240.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,773,838.00	45,433,240.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	169,160,000.00	211,094,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	35,500,000.00	58,330,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	16,056,800.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	16,056,800.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	875,031,388.81	555,153,470.30
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	447,530,141.00	608,128,568.85
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	447,530,141.00	608,128,568.85
2200	Дотоод эх үүсвэрээр	447,530,141.00	608,128,568.85
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	447,530,141.00	608,128,568.85
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(447,530,141.00)	(608,128,568.85)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	427,501,247.81	(52,975,098.55)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	427,501,247.81
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	427,501,247.81	374,526,149.26

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,939,702,673.59	5,455,233,525.17	(1,786,394,351.08)	6,608,541,847.68
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,939,702,673.59	5,455,233,525.17	(1,786,394,351.08)	6,608,541,847.68
9	Тайлант үеийн үр дүн	-	-	1,467,729,842.99	1,467,729,842.99
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,939,702,673.59	5,455,233,525.17	(318,664,508.09)	8,076,271,690.67
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,939,702,673.59	5,455,233,525.17	(318,664,508.09)	8,076,271,690.67
19	Тайлант үеийн үр дүн	-	-	368,833,572.79	368,833,572.79
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,939,702,673.59	5,455,233,525.17	50,169,064.70	8,445,105,263.46

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	7,658,247,600.00	7,582,554,471.00	75,693,129.00	99.0
12	Татварын бус орлого	7,658,247,600.00	7,582,554,471.00	75,693,129.00	99.0
120	Нийтлэг татварын бус орлого	637,009,200.00	579,222,670.00	57,786,530.00	91.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	637,009,200.00	579,222,670.00	57,786,530.00	91.0
122	Тусламжийн орлого	7,021,238,400.00	7,003,331,801.00	17,906,599.00	99.7
122005	Төсвөөс санхүүжих	7,021,238,400.00	7,003,331,801.00	17,906,599.00	99.7
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,992,895,200.00	7,635,529,569.55	357,365,630.45	95.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,992,895,200.00	7,635,529,569.55	357,365,630.45	95.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,680,913,500.00	7,341,872,329.55	339,041,170.45	95.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,824,673,800.00	4,756,697,144.51	67,976,655.49	98.6
210101	Үндсэн цалин	2,419,356,100.00	2,602,736,716.49	(183,380,616.49)	107.6
210102	Нэмэгдэл	2,169,884,600.00	1,571,643,575.13	598,241,024.87	72.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	235,433,100.00	278,496,437.56	(43,063,337.56)	118.3
210104	Урамшуулал	-	303,820,415.33	(303,820,415.33)	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	609,147,100.00	579,770,109.69	29,376,990.31	95.2
210201	Тэтгэврийн даатгал	414,220,100.00	405,137,978.45	9,082,121.55	97.8
210202	Тэтгэмжийн даатгал	48,731,700.00	44,720,617.78	4,011,082.22	91.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	24,365,900.00	23,601,009.90	764,890.10	96.9
210204	Ажилгүйдлийн даатгал	24,365,900.00	21,088,566.55	3,277,333.45	86.5
210205	Эрүүл мэндийн даатгал	97,463,500.00	85,221,937.01	12,241,562.99	87.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	175,336,000.00	168,019,793.25	7,316,206.75	95.8
210301	Гэрэл, цахилгаан	51,459,100.00	75,970,304.44	(24,11,204.44)	147.6
210302	Түлш, халаалт	107,600,600.00	82,895,937.65	24,704,662.35	77.0
210303	Цэвэр, бохир ус	16,276,300.00	9,153,551.16	7,122,748.84	56.2
2105	Нормативт зардал	258,558,000.00	189,184,800.00	69,373,200.00	73.2
210502	Хоол, хүнс	258,558,000.00	189,184,800.00	69,373,200.00	73.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	658,182,900.00	611,718,849.00	46,464,051.00	92.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	246,471,900.00	245,246,141.00	1,225,759.00	99.5
210602	Тавилга	90,000,000.00	46,295,720.00	43,704,280.00	51.4
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	41,623,700.00	41,047,150.00	576,550.00	98.6
210604	Урсгал засвар	280,087,300.00	279,129,838.00	957,462.00	99.7

Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	294,318,400.00	179,514,716.00	114,803,684.00	61.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	294,318,400.00	179,514,716.00	114,803,684.00	61.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	860,697,300.00	856,966,917.10	3,730,382.90	99.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	459,121,100.00	455,495,648.60	3,625,451.40	99.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	401,576,200.00	401,471,268.50	104,931.50	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	311,981,700.00	293,657,240.00	18,324,460.00	94.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	311,981,700.00	293,657,240.00	18,324,460.00	94.1
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	51,538,200.00	45,433,240.00	6,104,960.00	88.2
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	214,493,500.00	211,094,000.00	3,399,500.00	98.4
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	45,950,000.00	37,130,000.00	8,820,000.00	80.8
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	427,501,247.81		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	427,501,247.81	374,526,149.26		
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	138	126	12	91.3
620001	Удирдах ажилтан	6	6	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	112	104	8	92.9
620003	Үйлчлэх ажилтан	20	16	4	80.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Үйлдвэрлэл урлалын политехник коллеж эрхэм зорилгоо “Иргэд хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн, чадамжид суурилсан, мэдээллийн технологид тулгуурласан насан туршийн боловсрол, сургалтын үйлчилгээ үзүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Тус коллеж нь тайлант онд үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, цахилгаан хангамж тоног төхөөрөмжийн ашиглалт, зочид буудлын үйлчилгээ, өгөгдлийн сангийн загварчлал удирдлага, гоо сайхны үйлчилгээ 5 мэргэжлээр магадлан итгэмжлэгдсэн, мэргэжлийн боловсрол олгох сургалтыг 21 мэргэжлээр, техникийн боловсрол олгох сургалтыг 10 мэргэжлээр тус тус явуулж байна.

Чанарын нэгдсэн менежментийн ISO9001:2015,ISO21001:2018 олон улсын стандартын шалгуур, шаардлагыг хангаж, техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудаас анхдагч олон улсын нэгдсэн менежментийн гэрчилгээтэй сургууль болсон байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус коллеж нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжид нийцүүлэн чиг үүргээ хэрэгжүүлж байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрддөг хууль тогтоомж, бодлого чиглэлд тайлант хугацаанд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5 дах хэсэгт 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт орсон;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон;
- Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаал "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам" шинэчлэн батлагдсан;
- Сангийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 240 дүгээр "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ыг шинэчлэн батлах тухай тушаал;
- Сангийн сайдын 2025 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн А/112 дугаар "Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай" тушаал;
- Сангийн сайдын 2025 оны 09 дүгээр сарын 29-ний А/172 дугаар "Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" тушаал.

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний

үр дүнд 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 11 зорилтын хүрээнд 42 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 98.3 хувиар үнэлэгдсэн байгаа тул дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Үйлдвэрлэл урлалын политехник коллеж нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Үйлдвэрлэл урлалын политехник коллеж нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 344,324.4 мянган төгрөгөөр буюу 4.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	427,501.3	374,526.2	(52,975.1)
Авлага	114,930.0	105,006.8	(9,923.2)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	523,915.2	549,309.3	25,394.1
Үндсэн хөрөнгө	7,109,034.4	7,490,863.0	381,828.6
Нийт хөрөнгө	8,175,380.9	8,519,705.3	344,324.4
Өр төлбөр	99,109.2	74,600.0	(24,509.2)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	8,076,271.7	8,445,105.3	368,833.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	8,175,380.9	8,503,648.5	344,324.4

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 374,526.2 мянган төгрөг болж 52,975.1 мянган төгрөгөөр буурсан нь тайланд оны үйл ажиллагаанд зарцуулагдсан

- Авлагын дансны үлдэгдэл 105,006.8 мянган төгрөг болж 9,923.2 мянган төгрөгөөр буурсан нь сургалтын төлбөрийн авлагыг барагдуулсантай холбоотой.
- Бараа материал дансны үлдэгдэл 549,309.3 мянган төгрөг болж 25,394.1 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал нэмэгдсэнтэй холбоотой.
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 381,828.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд тайлант хугацаанд дараах хөдөлгөөн өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:
 - БНСУ-ын Койка олон улсын байгууллагаас 31,045.2 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн;
 - ТӨБЗГ-ын 2025 оны 10 дугаар тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 2,621,025.7 мянган төгрөгийн хөрөнгийн үнэ, ашиглах жилийг шинэчлэн тогтоож 282,100.0 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэсэн, төсвийн хөрөнгөөр 116,074.5 мянган төгрөгийн, өөрийн хөрөнгөөр 465,043.7 мянган төгрөгийн хөрөнгө худалдан тус тус худалдан авсан;
 - ТӨБЗГ-ын 2025 оны 347 дугаар тогтоолоор 1,850,508.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 586,539.7 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон;
- Өр төлбөр дансны үлдэгдэл 74,600.0 мянган төгрөг болж 24,509.2 мянган төгрөгөөр буурсан нь урьдчилж орсон сургалтын төлбөрийн орлогыг хүлээн зөвшөөрсөнтэй холбоотой байна.
- Засгийн хувь оролцоо дансны үлдэгдэл 368,833.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүн нөлөөлжээ.

Судалгааны үр дүн: Тус коллежийн программ хангамжийн дансанд бүртгэлтэй 2010 онд худалдан авч, ашиглаж байгаа 907.5 мянган төгрөгийн өртөгтэй санхүүгийн программ, 1,555.1 мянган төгрөгийн хөргөлтийн системийн туршилтын программ байна. Тайлант онд программ хангамж хөгжүүлэхтэй холбоотой зардал гараагүй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 6,658,803.5 мянган төгрөг, нийт зарлагыг 6,658,803.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал зардлыг 51,400.0 мянган төгрөгөөр, хичээл дадлагын материалын зардлыг 50,846.4 мянган төгрөгөөр, харуул хамгаалалтын зардлыг 2,400.0 мянган төгрөгөөр бууруулж, 6,554,157.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант оны улсын төсвөөс 524,342.8 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 579,747.7 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 334,647.6 мянган төгрөгийг

бүрдүүлэхээр батлагдсан төсвийг 1,438,738.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсөв захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээнд улсын төсвөөс 7,003,331.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлогоос . 579,747.7 мянган төгрөгийг бүрдүүлж зарцуулахаар батлагдсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 7,003,331.8 мянган төгрөгийн санхүүжилт, үйл ажиллагааны орлогоор 579,747.7 мянган төгрөг, бүрдүүлж, Урсгал үйл ажиллагаанд 7,635,529.6 мянган төгрөгийг зарцуулсан байна. Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлээс 52,450.1 мянган төгрөгийг зарцуулсан.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 7,635,529.6 мянган төгрөг буюу 95.5 хувьтай байгаа нь цалингийн зардал 67,976.7 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 29,377.0 мянган төгрөг, гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллын зарцуулах эрх 12 сард тавигдсан ба бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр зардал 111,370.4 мянган төгрөг, хоолны зардал 69,373.2 мянган төгрөг, тавилгын зардал 43,704.3 мянган төгрөг, нэг удаагийн шагнал урамшуулал зардал 8,820.0 мянган төгрөг, байр ашиглалтын зардал 7,316.2 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж 6,105.0 мянган төгрөг, бусад зардал 13,323.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Тус сургууль нь Ахмад настны тухай хуулийн дагуу 44,640.1 мянган төгрөгөөр ахмадын санг байгуулж, тайлант онд 28,583.3 мянган төгрөгийг зарцуулан үлдэгдэл 16,056.8 мянган төгрөгийг төвлөрүүлж, татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувь/
	71804-Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх арга хэмжээ	7,992,895.2	7,635,529.6	357,365.6	95.5
1	80219-Харуул хамгаалалтын зардал	69,600.0	66,166.7	3,433.3	95.1
2	80226-Байр ашиглалтын үйлчилгээ	220,836.1	213,482.2	7,353.9	96.7
3	81802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	266,031.7	256,527.2	9,504.5	96.4
4	81806-Дотуур байрны үйлчилгээ	258,558.0	189,184.8	69,373.2	73.2
5	81834-Боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийн хэрэгжилт	5,778,929.6	5,680,894.5	98,035.1	98.3
6	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	699,726.5	588,220.4	111,506.1	84.1
7	81844-Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалт	699,213.3	641,053.8	58,159.5	91.7

Судалгааны үр дүн: Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн

тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл"-ийн дагуу аудитын явцад тус байгууллагаас дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ.

1. Тайлант онд 138 орон тоо батлагдсанаас гүйцэтгэлээр 126 орон тоогоор ажилласан байна. Тус коллеж нь тайлант онд 5 багш нярайн асрах чөлөөтэй, 1 дотоод хяналтын ажилтан тэтгэвэрт гарч нэмж ажилтан аваагүй байна. Мөн 1 багш, 1 нярав, 1 слесарь, 3 үйлчлэгчийн ажлын байрны 6 зар тавиад хүн ирээгүй тул хавсран ажиллуулж байна.
2. Боловсролын сайдын 2025 оны 1/554 дүгээр "Чиглэл хүргүүлэх тухай" албан бичгийг үндэслэн захирлын 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/08 дугаар тушаалаар хоолны тарифыг 8.0 мянган төгрөгөөр тогтоож тайлант хугацаанд 278,496.4 мянган төгрөгийн хоол, унааны хөнгөлөлт олгосон.
3. "Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагыг магадлан итгэмжлэх үйл ажиллагаа", архив. албан хэрэг хөтлөлт, хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын зардалд нийт 52,622.0 мянган төгрөг зарцуулсан.
4. Гадаад томилолтоор ажиллаагүй, хэвлэл, мэдээллийн байгууллагаар гэрээт ажил гүйцэтгүүлээгүй, программ хангамжтай холбоотой болон төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Үйлдвэрлэл урлалын политехник коллеж нь тайланд онд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 805,532.1 мянган төгрөгийн 3 бараа, ажил үйлчилгээ, харьцуулалтын аргаар 239,600.0 мянган төгрөгийн 3 бараа, ажил үйлчилгээ нийт 1,045,132.1 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 6 худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

Хичээл үйлдвэрлэлийн дадлагын 234,950.8 мянган төгрөгийн материалыг шууд худалдан авч худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Үйлдвэрлэл, урлалын политехник коллеж, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Пийк ОМ Аудит ХХК-ийн ахлах аудитор А.Мөнхцэцэг, аудитор А.Батболд нар гүйцэтгэж, захирал Б.Жаргалсайхан анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Батхишиг, аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Үйлдвэрлэл урлалын Политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 1/11 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн 6,357,905.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 63,579.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон болон хязгаарласан арга хэмжээг санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайланд хугацаанд 171 мэдээллийг хуулийн хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, орлого, бараа материал, үндсэн хөрөнгийн дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар илэрсэн 146,572.3 мянган төгрөгийн 3 алдааг залруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 7,780.6 мянган төгрөгийн төлбөрийн акт, 14,332.1 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	7,780.6	2	7,780.6	100.0
Зөвлөмж	3	14,332.1	3	14,332.1	100.0
Нийт дүн	5	22,112.7	5	22,112.7	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу санхүүгийн тайланг иж бүрэн, үнэн зөв, тодруулгуудын хамт бэлтгэж байгаа эсэхийг дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 29,716.3 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснээс аудитын явцад 29,716.3 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

- Тайланд үед хичээлийн байрны 3 хаалгыг 10,830.0 мянган төгрөгөөр худалдан авч шинэчилснийг бараа материалын үлдэгдлээр тайлагнасан.
- Тайлант хугацаанд худалдан авсан принтер, өсгөгч, дулааны тоолуур зэрэг 18,886.3 мянган төгрөгийн 4 хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн зэрэг нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга, 1.27 “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой” гэсэн заалттай нийцээгүй байсныг залруулав.

Аудитаар нийт 256,202.7 мянган төгрөгийн 3 зөрчил² илэрсэнд, 234,950.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 21,251.9 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 256,202.7 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 63,579.1 мянган төгрөгөөс давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

5.2 Албан шаардлага

1.Илрүүлэлт: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нарийвчлан тооцож, боловсруулаагүйгээс тендерт оролцогч орж ирээгүй, цахим дэлгүүрт шаардлагатай материал байхгүй гэх шалтгаанаар 234,950.8 мянган төгрөгийн хичээл үйлдвэрлэлийн дадлагын материалыг шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 "Захиалагч дараах үндэслэлээр аж ахуй эрхлэгчдийн дунд хэлэлцээ хийх замаар гэрээ шууд байгуулж болно: 35.1.1. Захиалагч урьдчилан мэдэх боломжгүй нөхцөл байдлын улмаас бараа, ажил, үйлчилгээ худалдан авах яаралтай хэрэгцээ үүссэн шалтгаанаар энэ хуульд заасан бусад аргаар тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй. Тайлбар: Энэ заалтын дагуу гэрээ шууд байгуулахад өмнөх тендер шалгаруулалт амжилтгүй болсон, захиалагчаас хамаарах шалтгаанаар худалдан авах ажиллагаа удааширсан, эсхүл төсвийн жил дуусаж санхүүжилтийн эх үүсвэргүй болох нөхцөл байдал хамаарахгүй", 41 дүгээр зүйлийн 41.1 "Худалдан авах гэрээ дараах нөхцөлийн аль нэгд хамаарах бол илт хууль бус байна: 41.1.1. Энэ хуулийг зөрчиж гэрээ шууд байгуулсан", 44 дүгээр зүйлийн 44.1 "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалаар батлагдсан

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

"Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.2 "Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулахгүй байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хөрөнгийн ангилал, ашиглалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас сургалтын үйл ажиллагаанд зориулан худалдан авсан 2,299.5 мянган төгрөгийн кофе чанагчийг үндсэн хөрөнгөнд бүртгээгүй, бараа материалаар ангилан бүртгэж, оюутнуудын хичээлд ашиглахгүй, сургалтын менежерийн хэрэгцээнд ашиглаж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийг зөв ангилан бүртгэх, хөрөнгөнд тавих хяналтыг сайжруулж хичээл үйлдвэрлэлийн дадлагын хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах

2. Бараа материалын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Бараа материалын дансанд 18,952.4 мянган төгрөгийн "Ажлын хөлс, бараа материал" гэсэн нэршилтэй 4 төрлийн хөрөнгө бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, зааврын дагуу шалгуур хангасан хөрөнгийг бүртгэлд тусгах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
	Тайланд үед хичээлийн байрны 3 хаалгыг 10,830.0 мянган төгрөгөөр худалдан авч шинэчилснийг бараа материалын үлдэгдлээр тайлагнасан байна.	1	10,830.0			1	10,830.0	1	10,830.0				
	Тайлант хугацаанд худалдан авсан принтер, өсгөгч, дулааны тоолуур зэрэг 18,886.3 мянган төгрөгийн 4 хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн байна.	1	18,886.3			1	18,886.3	1	18,886.3				
	Дүн	2	29,716.3			2	29,716.3	2	29,716.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нарийвчлан тооцож, боловсруулаагүйгээс тендерт оролцогч орж ирээгүй, цахим дэлгүүрт шаардлагатай материал байхгүй гэх шалтгаанаар 234,950.8 мянган төгрөгийн хичээл үйлдвэрлэлийн дадлагын материалыг шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.	1	234,950.8			1	234,950.8						
2	Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас сургалтын үйл ажиллагаанд зориулан олж бэлтгэсэн 2,299.5 "Кофе чанагч"-ыг Үндсэн хөрөнгөнд бүртгээгүй, бараа материалаар ангилан бүртгэж, оюутнуудын хичээлд ашиглахгүй, сургалтын менежерийн хэрэгцээнд ашиглаж байна.	1	2,299.5					1	2,299.5				
3	Бараа материалын дансанд 18,952.4 мянган төгрөгийн "Ажлын хөлс, бараа материал" гэсэн нэршилтэй 4 төрлийн хөрөнгө бүртгэсэн байна	1	18,952.4					1	18,952.4				
Дүн		3	256,202.7	-	-	1	234,950.8	2	21,251.9	-	-	-	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 306/А0150458

Улаанбаатар хот

САГ-2026/246/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нарийвчлан тооцож, боловсруулаагүйгээс тендерт оролцогч орж ирээгүй, цахим дэлгүүрт шаардлагатай материал байхгүй гэх шалтгаанаар 234,950,761.00 /Хоёр зуун гучин дөрвөн сая есөн зуун тавин мянга долоон зуун жаран нэгэн/ төгрөгийн хичээл үйлдвэрлэлийн дадлагын материалыг шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-т "Захиалагч дараах үндэслэлээр аж ахуй эрхлэгчдийн дунд хэлэлцээ хийх замаар гэрээ шууд байгуулж болно: 35.1.1. Захиалагч урьдчилан мэдэх боломжгүй нөхцөл байдлын улмаас бараа, ажил, үйлчилгээ худалдан авах яаралтай хэрэгцээ үүссэн шалтгаанаар энэ хуульд заасан бусад аргаар тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй", 41 дүгээр зүйлийн 41.1-т "Худалдан авах гэрээ дараах нөхцөлийн аль нэгд хамаарах бол илт хууль бус байна: 41.1.1. Энэ хуулийг зөрчиж гэрээ шууд байгуулсан", 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.2-т "Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол"-д заасныг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Худалдан авах ажиллагааг хууль тогтоомж, заавар, журмын дагуу зохион байгуулахгүй байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн захирал /Д.Буяндэлгэр/, нягтлан бодогч /П.Сарантуяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

[Signature]

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
А.МӨНХЦЭЦЭГ